

## **“ЦЭРГИЙН ТӨВ ЭМНЭЛГИЙН ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ ШИНЭЧЛЭХ ТӨСЛИЙН ГУРАВДУГААР ҮЕ ШАТНЫ ТӨСӨЛ”-ИЙН ТАНИЛЦУУЛГА**

### **Нэг. Төслийн мэдээлэл**

#### ***Төслийн зорилго:***

Ард иргэд, Зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандартын шаардлагын түвшинд хүрч, үйлчлүүлэгчид үзүүлэх эмчилгээ, оношилгооны чадавхад томоохон хэмжээний ахиц, дэвшил гарна. Цэргийн албан хаагчид өндөр мэдрэмжит шинжилгээ үйлчилгээнд хамрагдахын тулд бусад эмнэлэгт хандахгүйгээр эрүүл мэндийн даатгалын хөнгөлөлттэй үнээр түргэн шуурхай оношилгоо, эмчилгээнд хамрагдах боломж бүрдэнэ. Төслийг хэрэгжүүлснээр Цэргийн төв эмнэлэгт урд өмнө нь хийгдэх боломжгүй байсан оношилгоо, эмчилгээнүүдийг хийж, ард иргэдийн гадаад орон руу явж эмчлүүлэх урсгалыг багасгаж, эх орондоо харьцангуй хямд өртгөөр эмчлүүлэх боломжийг бүрдүүлэх бөгөөд дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн:

- Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төвийн Хор судлалын лаборатори;
- Цус шүүх, цэвэршүүлэх эфферент эмчилгээ;
- Бүх төрлийн уян дурангийн оношилгоо, эмчилгээ;
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх Цусны банк;
- Эрхтэн шилжүүлэх мэс засал;
- Олныг хамарсан гамшиг, ослын амь тэнссэн үед ашиглагдах хээрийн эмнэлгийн чадамж, чадавхыг дээшлүүлэн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмжийн шинэчлэл хийх.

#### ***Төслийн хэрэгжих хугацаа: 2 жил***

#### ***Төслийн байршил: Цэргийн төв эмнэлэг***

#### ***Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичигт туссан байдал:***

*“Алсын хараа -2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа:*

• 2.2.11. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг хүн амын нягтрал, газар зүйн байршил, хүн ам зүйн бүтэц, өвчлөл, шилжилт хөдөлгөөн, хүн амын эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний эрэлт хэрэгцээтэй уялдуулан зохион байгуулна;

• 2.2.12. Төр, хувийн хэвшил, иргэний нийгмийн байгууллагуудын түншлэлийн хүрээнд эрүүл мэндийн тусламжийн ачааллыг тэнцүүлж хүн амд чанартай, аюулгүй, тэгш хүртээмжтэй “Үйлчлүүлэгч төвтэй” тусламж, үйлчилгээ үзүүлэх чадавх бүхий эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагуудыг дэмжинэ;

• 2.2.28. Эрүүл мэндийн технологийн чиглэлээр хөрөнгө оруулалт хийх, дэвшилтэт технологи нэвтрүүлэх үйл ажиллагааг төрөөс дэмжинэ.

## Хоёр. Төслийн санхүүжилт, нөхцөл

№	Тоног төхөөрөмжийн багцын ангилал	Тоо хэмжээ	Нийт дүн (Евро)
1	Хор судлалын лабораторийн тоног төхөөрөмж	12	152,206.00
2	Хордлогын эфферент эмчилгээний тоног төхөөрөмж	15	386,271.00
3	Донор зохион байгуулалтын хэсэг	31	438,375.00
4	Үйлдвэрлэлийн тасаг	44	398,068.00
5	Яаралтай тусламжийн тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	251	1,920,975.00
6	Эрхтэн шилжүүлэх мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл	45	2,279,478.80
7	Гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж багаж хэрэгсэл	10	296,205.60
8	Мэдрэлийн эмгэг судлалын тоног төхөөрөмж	3	180,000.00
9	Дүрс оношилгооны тоног төхөөрөмж	6	3,948,420.60
НИЙТ		417	10,000,000.00

## Гурав. Төслийн хүрээнд хийгдэх ажил, үр дүн

Төслийн хүрээнд дараах чиглэлийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслүүдийг шинээр нэвтрүүлнэ:

- Хор судлалын лаборатори;
- Цус шүүх, цэвэршүүлэх эфферент эмчилгээ;
- Цус, цусан бүтээгдэхүүн үйлдвэрлэх;
- Зүрхний мэс засал;
- Мэдрэлийн эмгэгийн оношилгоо;
- Олныг хамарсан гамшиг, ослын амь тэнссэн үед ашиглагдах хээрийн эмнэлгийн орчин үеийн дэвшилтэт техник, технологи бүхий эмнэлгийн тоног төхөөрөмж.

Мөн тоног төхөөрөмжийн хүчин чадал, оношилгоо, эмчилгээний чадавхыг сайжруулах чиглэлээр тоног төхөөрөмж, багаж хэрэгслийг нэмэгдүүлэх чиглэлүүд. Үүнд:

- Гэмтлийн мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл;
- Эрхтэн шилжүүлэх мэс заслын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл;
- Бүх төрлийн уян дурангийн оношилгоо, эмчилгээ;
- Дүрс оношилгооны тоног төхөөрөмж.

Цэргийн төв эмнэлгийн Хордлогын яаралтай тусламжийн үндэсний төв, Гэмтлийн болон Мэс заслын эмнэлзүйн төв, Яаралтай тусламжийн тасгуудын техник, тоног төхөөрөмжийн чадамж, хангалтыг өндөр хөгжилтэй орнуудын цэргийн эмнэлгийн жишигт хүргэн, Цусны банк байгуулснаар үндэсний хэмжээнд “Аврахуйн анагаах ухаан”-ы чиглэлээр тэргүүлэх, жишиг, лавлагаа шатлалын эмнэлэг болж хөгжих үндэс бүрдэнэ. Цусны банк байгуулснаар 1 жилд 300 сая орчим төгрөгийн цус, цусан бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн өөрийн хэрэгцээнд нийлүүлэх боломжтой болно.

Улсын хэмжээнд эм, химийн бодист хордлогод өртсөн ард иргэдийн эрүүл мэндийг хамгаалах болон үзүүлэх эмнэлгийн тусламж, үйлчилгээний чанар олон улсын стандарт түвшинд хүрэх боломж бүрдэнэ.

Олныг хамарсан байгалийн болон үйлдвэрлэлийн осол, гэмтлийн үед тухайн газар оронд нь очиж аврах, яаралтай тусламжийг үзүүлэх, тээвэрлэх, эмчилж хор уршгийг арилгах боломж нэмэгдэж, тус эмнэлгийн иргэдэд үзүүлэх амь тэнссэн үеийн болон гэмтэл, мэс заслын яаралтай тусламж, үйлчилгээний чанар, хүртээмж, бэлэн байдал хангагдана.

---oOo---